



МҮХАҮТ

7 ХОНОГИЙН ТОЙМ



2026.06.02 – 2026.06.05

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 26.10



BUSINESS
ACADEMY

ИРЭЭДҮЙГ ТҮҮЧЭЭЛЭХ КОМПАНИУДЫН ЗААВАЛ СОНГОХ ОНЦЛОХ СУРГАЛТУУД

☎ 9027-9070, 9913-8186, 9906-0039



Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах нь



Ажлын байран дахь сургагч, дадлагажуулагчийн хөтөлбөр



Стресс менежмент, харилцааны ур чадвараа удирдахуй



ELSA AI Англи хэлний сургалт

...>

БУСАД НҮҮРЭНД



Олон улсын хөдөлмөрийн 114 дүгээр бага хурал Женев хотноо боллоо

...>



Худалдаа болон жөндөрийн албан бус бүлгийн хуралдаан боллоо

...>



Ноос ноолуурын зөвлөлийн хурал боллоо

...>



Гишүүнчлэлийн гэрчилгээгээ албан ёсоор гардан авлаа

...>




Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх боломжийг ярилцлаа

...>



Мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр төр, хувийн хэвшил хамтарна

...>



“Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах нь” сэдэвт онлайн сургалт боллоо

...>



МҮХАҮТ, Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт хамтран ажиллана

...>



“Цөлийн дуу хоолой” олон улсын санаачилга албан ёсоор нээлтээ хийлээ

...>



“Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ” сэдэвт олон улсын курс сургалтад хамрагдлаа

...>



Сургалт, Бизнес форум ба Үзэсгэлэнгүүд

...>



2026.09.17-20

7 ХОНОГИЙН ТОЙМ

Олон улсын хөдөлмөрийн 114 дүгээр бага хурал Женев хотноо боллоо



Олон улсын хөдөлмөрийн 114 дүгээр бага хуралд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Саруул оролцлоо. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг тус бага хурал нь



олон улсын хөдөлмөрийн стандартыг боловсруулах, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах дэлхийн хэмжээний хамгийн өндөр түвшний гурван талт механизм юм.

Худалдаа болон жендэрийн албан бус бүлгийн хуралдаан боллоо



Швейцарын Женев хотноо болсон ДХБ-ын Худалдаа болон жендэрийн албан бус бүлгийн хуралдаанд МҮХАҮТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Саруул оролцлоо

Тэрээр уулзалтын үеэр цахим эдийн засаг дахь эмэгтэй экспортлогчдыг дэмжих “WEIDE” сангийн хэрэгжилт



болон “SheTrades Mongolia Hub”-ын үр дүнг танилцуулж, цаашид хамтарсан төслүүд хэрэгжүүлэхээр тохиролцов. Мөн энэ үеэр МҮХАҮТ болон Олон улсын худалдааны төв (ОУХТ) хоорондын “SheTrades hub Mongolia” санаачилгыг үргэлжлүүлэх Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

Ноос ноолуурын зөвлөлийн хурал боллоо




МҮХАҮТ-ын дэргэдэх Ноос, ноолуурын зөвлөлийн ээлжит хурлаар тус зөвлөлийн шинэ даргаар “Монгол Кашмер” ХХК-ийн үүсгэн байгуулагч, “Mongolian Eco Textile Export Cluster” ТББ-ын тэргүүн Э.Эрхэмхүүг сонголоо.



Ноос, ноолуурын салбарт 11 дэх жилдээ ажиллаж буй тэрээр салбарын хөгжлийг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж ирсэн туршлагатай юм.

“Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах нь” сэдэвт онлайн сургалт боллоо

Уг сургалтаар компаниудад өөрийн байгууллагын онцлог, хэрэгцээнд тохирсон санхүүжилтийн оновчтой шийдлийг сонгоход нь практик зөвлөгөө өгч, хөрөнгийн зах зээлийн давуу талуудыг таниулсан юм.



Гишүүнчлэлийн гэрчилгээгээ албан ёсоор гардан авлаа



МҮХАҮТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Саруул Олон улсын ажил олгогчдын байгууллага (IOE)-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Роберто Суарестэй уулзаж, гишүүнчлэлийн гэрчилгээгээ албан ёсоор гардан авлаа. Энэхүү түншлэл нь дотоодын аж ахуйн нэгжүүдэд дэлхийн шилдэг туршлага, бодлогын мэдээлэл болон олон улсын зах зээлд нэвтрэх өргөн боломжийг олгож буй юм. Уулзалтын үеэр МҮХАҮТ Олон улсын хөдөлмөрийн бага хурал (ILC)-ын Жендэрийн хорооны хуралдаанд Монгол Улсын сайн туршлагаас хуваалцаж, идэвхтэй оролцсоныг талууд онцлов.

Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх боломжийг ярилцлаа



Экспорт, импортлогчдод практик дэмжлэг үзүүлэх зорилготой “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулсан Худалдааны түр хэлэлцээр: ОХУ-ын Холбооны гаалийн албаны



зөвлөмж ба асуулт хариулт” сэдэвт уулзалт, семинар боллоо. Уулзалтаар бизнес эрхлэгчдэд хамгийн хэрэгцээтэй гол асуудлуудыг онцлон хэлэлцсэн байна.

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр төр, хувийн хэвшил хамтарна



Боловсролын яам, МҮХАҮТ болон Монголын техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулиудын консорциум хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Талууд Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”

болон боловсролын салбарын шинэчлэлийг дэмжих, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд анхаарах юм. Үндэсний ур чадвартай боловсон хүчний эрэлт хэрэгцээ нэмэгдэж буй энэ үед талууд бодлого, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахаар тохиролцлоо.



7 ХОНОГИЙН ТОЙМ

МУХАУТ, Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт хамтран ажиллана



сургалт зохион байгуулах, салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг дэмжихэд талууд анхаарч ажиллах юм.



Хамтын ажиллагааны хүрээнд дотоодын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн менежментийн чадавхыг дээшлүүлэх, зөвлөх үйлчилгээний зах зээлийг бэхжүүлэх, олон улсын жишигт нийцсэн сургалт, хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцов. Мөн ЖДБ эрхлэгчдэд зориулсан сертификатай

“Цөлийн дуу хоолой” олон улсын санаачилга албан ёсоор нээлтээ хийлээ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж буй “Цөлийн дуу хоолой” (Voice of the Desert) төслийн нээлтийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээ нь манай улсад

болох НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын XVII бага хурал (UNCCD COP17)-ыг угтан, төслийн үзэл санааг олон нийтэд танилцуулах зорилготой юм.



“Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ” сэдэвт олон улсын курс сургалтад хамрагдлаа

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын (МУХАУТ) Бодлого, стратегийн газрын хуулийн мэргэжилтэн Ц.Ариунжаргал Олон улсын хөдөлмөрийн байгууллага – International Labour Organization-ын



дэмжлэгтэйгээр Итали Улсын Турин хот дахь ОУХБ-ын Олон улсын сургалтын төвөөс зохион байгуулагдсан “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ” сэдэвт олон улсын курс сургалтад хамрагдлаа.

Бизнес АКАДЕМИ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ СУРГАЛТ

2026 оны 06 сар 18-19

training@mongolchamber.mn | Бизнес академи | 9027-9070, 9903-1573

СУРГАЛТ, БИЗНЕС ФОРУМ БА ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

UBX Ulaanbaatar Securities Exchange

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ ONLINE СУРГАЛТ

СТРАТЕГИАР ХӨРӨНГӨ ОРУУЛ • ИРЭЭДҮЙГЭЭ БҮТЭЭ

ХӨТӨЛБӨР

- ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ОЙЛГОЛТ
- ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ СТРАТЕГИ БА БЭЛТЭЛ
- ҮНЭТ ЦААС ГАРГАХ ПРОЦЕСС
- БОДИТ ТУРШЛАГА, АСУУЛТ ХАРИУЛТ

МЭДЛЭГЭЭР ИРЭЭДҮЙГЭЭ ӨӨРЧИЛЬЕ!

04th JUNE 2026 | 16:00 | ONLINE

БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ!

Хязгаарлагдмал тооны оролцогчдод зориулав.

www.ubx.mn

Ажлын байран дахь

СУРГАГЧ, ДАДЛАГАЖУУЛАГЧ ХӨТӨЛБӨР

Bazaar BERLIN

4 – 8 November 2026

300 ОРОЛЦОГЧИД | 28 УЛС | 35,000 ҮЗЭГЧИД

Монгол-Австрийн ДУГУЙ ШИРЭЭНИЙ БИЗНЕС УУЛЗАЛТ

MONGOLIA-AUSTRIA BUSINESS ROUNDTABLE

2026.06.16 | 15:00-17:00

16 June 2026 | Ulaanbaatar, Mongolia

77277070 (6), 99033339 | foreignrelations@mongolchamber.mn